



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 07 дугаар сарын 01


Улаанбаатар хот

Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 бүлэг, 46 зорилт, 158 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн, тус газрын удирдлага Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/47 дугаартай “Хариуцлагын гэрээ” байгуулав. Үүнд:

Хүснэгт 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээ:

№	Зорилго	Зорилтын тоо	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1	Төсөл арга хэмжээний хүрээнд	6	7	92,8%
2	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд	29	61	83,7%
3	Хуулиар хүлээх чиг үүргийн хүрээнд	10	86	93,9%
4	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	1	4	92,5%
Нийт		46	158	89.9%

Зураг 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 158 ажил, арга хэмжээний хэрэгжилтийн хувь:



Үүнээс бүрэн хангалттай (85%-иас дээш) 122 арга хэмжээ, хангалттай (70-84% хүртэл) 21, хангалтгүй (69% хүртэл) 14, хугацаа болоогүй 1 арга хэмжээ үнэлэгдэж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх тухай” А/905 дугаар захирамжаар “ХАНГАЛТТАЙ” ангиллаар дүгнэгдсэн.

ЗОРИЛГО 1. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Метро төслийн трассыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 411 дүгээр тогтоолоор нийслэл Улаанбаатар хотод Олон Улсын чанар стандарт, шаардлагыг бүрэн хангасан Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Хот байгуулалт, хотын стандартын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/71 дүгээр тушаалаар Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн зөвлөх үйлчилгээний ажлын орон зайн төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн хүрээнд санал, зөвлөмж өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг томилсон. Тус ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж санал өгч, ажлын зураг төсөл зөвшилцөж ажиллав. Төслийн зөвлөх үйлчилгээний баг болох БНСУ-ын “Духуа инженеринг” ХК болон түншлэлийн гишүүд Korea National Railway, Korail, Soosung engineering ХХК нь Техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн, загвар зураг төсөл боловсруулж, Нийслэлийн нутаг дэвсгэрт Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 08 дугаар хурлаар 15 байршилд Метроны буудал, 1 Депо бүхий 19.01 км урттай загвар зургийг хэлэлцэн дэмжигдэж, батлуулав.

Зураг 2. Улаанбаатар метро трасс.



Тусгай замын автобусны трассыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх.

Буянт-Ухаа спорт цогцолбороос 120 мянгатын уулзвар, Сүхбаатарын талбай хүртэл 13.1 км урттай болон Ард Аюушийн өргөн чөлөө, Их тойруу Намъянжүгийн гудамж, Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урттай “Тусгай замын автобус” /BRT/ төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ажил жагсаалтад эрэмбэлэгдсэн.

Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажил, төрийн болон төсөвт байгууллагын үндсэн чиг үүргийн дагуу зайлшгүй хэрэгцээнд газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахыг тусган Хот байгуулалт, хотын стандартын газар болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хариуцуулсан.

“Тусгай замын автобус” /BRT/ төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) боловсруулах ажлын хүрээнд инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний тодруулгыг гарган ажиллаж байна.

Хөнгөн галт тэрэг төслийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх.

“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТУГ-аас ирүүлсэн архитектур төлөвлөлтийн даалгавар гаргуулах тухай хүсэлтийн дагуу Монгол Улсын Сайд 20 минутын хот Үндэсний хорооны даргын А/10 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1370, А/1553 дугаар “Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг нэвтрүүлэх төсөл”-ийн Техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг, төсөв боловсруулах, “Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай” чиглэлд олон төрөлт нийтийн

тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төслийн техник эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв боловсруулах захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Үүнд:

- Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох – 10.8 км урт хойд трассын дагуу газар олголт, хот байгуулалт, төлөвлөлтийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн МЗХ2025/00-214 дугаартай гол гудамж замын ангиллын Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар гарсан.
- Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас Сүхбаатарын талбай чиглэлд – 15.3 км урт урд трассын дагуу газар олголт, хот байгуулалт, төлөвлөлтийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 2025/00-219 дугаартай гол гудамж замын ангиллын Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлагдан гарсан.

Дүүжин тээврийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу санал өгч ажлын зураг төсөл зөвшилцөх


Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр Яармаг орчмоос Баянгол, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр Хархорин худалдааны төв хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт “Агаарын дүүжин замын тээвэр” төслийн бүтээн байгуулалтын ажлыг Франц Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр гүйцэтгэж байна

“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-ын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 1/101 дугаартай албан бичгийг үндэслэн ХУД-ийн 23-р хороо, Яармаг Арцат буудлаас БГД-ийн 29-р хороо, Хархорин худалдааны төвийн автобусны буудал /Өнөр хороолол/ хүртэлх агаарын дүүжин замын 2023 оны 04 дүгээр сарын 17-ний өдрийн МЗХ2023/09-013 дугаартай даалгаврын Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Яармаг талын зогсоолд өөрчлөлт оруулан 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 2025/00-164 дугаартай Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар батлуулсан.

“Туул усан цогцолбор төсөл”-ийг барьж байгуулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэст хөрөнгийг нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд тусгуулахаар саналаа 2025 оны 01/486 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. БОУАӨЯ, Усны газар, Энэтхэгийн Засгийн газрын хэлэлцээрээр хийгдэж байгаа “Туул усан цогцолбор”-ын ТЭЗҮ боловсруулах ажлын хэлэлцүүлэгт оролцож, санал өгсөн.

Зураг 3. “Туул усан цогцолбор” төсөл.



“Туул усан цогцолбор” төслийн ТЭЗҮ-д шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх ажлын хүрээнд НЗДҮАХ-ийн 2024-2028 хөтөлбөрт төр, хувийн хэвшлийн санхүүжилтээр нийт 2,245,811.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төсөвлөснөөс 2025 онд ТЭЗҮ, ажлын зураг боловсруулахад 48,052.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын саналаа өгсөн.


Нийслэлийн 2025 оны төсвийн саналд нийт 112,064.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, үүнээс 2025 онд ТЭЗҮ боловсруулахад 9,000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тусгуулахаар саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Дулааны II дугаар цахилгаан станцын хүчин чадлыг 300МВт (1 агрегат нь тохируулгын горимд ажиллах хийн генератор бүхий)-аар өргөтгөж, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг зөвшилцөх.

Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны А/55, А/124 дүгээр тушаал, захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан.

Тус ажлын хэсгийн хүрээнд Хот байгуулалт, хотын стандартын газар нь нийслэлийн Орон сууцны бодлогын газар, бусад төслийн нэгжүүдтэй хамтран 2025-2028 он, 2029-2032 он хүртэл хэрэгжих төсөл хөтөлбөрт шаардлагатай дулааны хэрэглээг тооцон боловсруулсан бөгөөд 2029-2032 онд хэрэгжүүлэх орон сууцны төслүүдийн хүрээнд дулааны II дугаар цахилгаан станцын хүчин чадлыг 300МВт-аар өргөтгөхөөр тусгасан ба ээлжит ажлын хэсгийн хуралд дулааны шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл гаргаж танилцуулга бэлтгэж хэлэлцүүлсэн.

Зураг 4. Дулаан хангамжийн төлөвлөлт.




Нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Нийслэлийн дулаан, эрчим хүчний хэрэглээний оргил ачааллын үед ажиллах дулааны тархмал эх үүсвэрийн газар олголтын асуудлыг тусгуулан батлуулсан. Үүнд:

- Баянзүрх дүүргийн 26-р хорооны нутаг дэвсгэрт Хийн дулааны эх үүсвэр барих 6.1 га талбай,
- Баянзүрх дүүргийн 26-р хорооны нутаг дэвсгэрт Хийн дулааны эх үүсвэр барих 1.9 га талбай,
- Хан-Уул дүүргийн 8-р хороо, Жаргалантын ам, Дулааны эх үүсвэр барих 3.8 га,

- Хан-Уул дүүргийн 11-р хороо, ХААИС-ын Агропаркийн хашаанд Хийн түлшээр ажиллах дулааны эх үүсвэр барихад 1.8 га.

Зураг 4. Оргил ачааллын эх үүсвэрүүдийн байршил.



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/15 дугаар захирамжаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус IV хуралдааныг 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр зарлан хуралдуулж, Эрчим хүчний яамнаас “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачаалалд ажиллах дулааны тархмал эх үүсвэр”-ийн танилцуулгыг хийсэн. Тус хуралдаанаар төлөвлөж буй тархмал эх үүсвэрийн байршилд байгаль орчны төлөв байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгүүлэх шаардлагатай бөгөөд байгаль орчны үнэлгээг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар дахин хэлэлцүүлэхээр шийдвэр гарсан.

ЗОРИЛГО 2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Хот байгуулалт болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж өөрчлөлт оруулах тухай саналыг холбогдох газарт хүргүүлэх.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хүрээнд:

Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт хэмжил зүйн газар, Шадар сайдын ажлын албатай 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хамтарсан уулзалтад оролцон хотын стандартын эрх, зүйн орчныг сайжруулах, Захиргааны ерөнхий хуультай уялдуулах талаар саналаа өгсөн. Үүнд:

101 дүгээр зүйл. Хотын стандарт.

101.1. Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд стандарт батлан хэрэгжүүлж болно.

101.2. Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Стандарт, хэмжил зүйн газраас 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Барилгын салбарын стандартын өнөөгийн байдалд тулгамдаж буй асуудал” нээлттэй хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Газрын дарга хотын стандартын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал сэдвийн хүрээнд танилцуулга, илтгэл тавьж оролцсон. 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр тус хэлэлцүүлгийн үр дүнг хэлэлцсэн.

Хууль тогтоомж, стандартын төсөлд санал өгөх ажлын хүрээнд 7 хууль, 4 журам, 1 дүрмийн төсөлд саналаа өгч, холбогдох газарт хүргүүлэв.

Хотын стандартыг хот байгуулалт болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартад нийцсэн талаарх үзлэг, судалгаа хийх.

Газрын даргын 2024 оны А/79 дүгээр “Ажлын хэсэг байгуулах” тухай тушаалын хүрээнд:


- Хотын стандартыг холбогдох салбарын хууль, журам, норм ба БНБД-тэй нийцсэн эсэх талаарх саналыг авсан.
 - Газрын нийт алба, хэлтсүүдээс санал авч, нэгтгэлийг Ажлын хэсэг хэлэлцсэн. (14 норм ба дүрэм)
 - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсрол яам, Барилгын хөгжлийн төв болон Нийслэлийн нутгийн захиргааны 31 байгууллагуудад Нийслэлийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хотын стандарт, салбарын хууль, тогтоомжид нийцэж буй эсэх талаар санал авахаар 2025 оны 01/392, 01/393 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу 9 байгууллагаас 30 санал ирсэн. Үүнд:
- ✓ Ерөнхий санал - 8
 - ✓ Тухайлсан санал - 22

Дээрх саналуудад дүн шинжилгээ хийж, Газрын даргад танилцуулсан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 52 хотын стандартад чиг үүргийн дагуу үзлэг судалгааг хийж байна.

“Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г Улсын Их Хуралд өргөн барьж, батлуулах ажлыг зохион байгуулах.

Засгийн газрын 2024 оны 33 дугаар хуралдаанаар тэмдэглэлд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний төслийг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн шинэчлэлд нийцүүлэн боловсруулах үүрэг өгөгдсөн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1189 дүгээр захирамжийн хүрээнд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын гүйцэтгэгч “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж, захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Зураг 5. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх ХЕТ батлагдах үе шат.



Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” төслийг хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн.

Зураг 6. УИХ-д тогтоолын төсөл өргөн мэдүүлэх үйл явц.



“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г олон нийтэд танилцуулах ажлын хүрээнд:


1. НИТХ-ын даргын 2025 оны А/02 дугаар захирамжаар “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г УИХ-ын гишүүд, Нийслэл, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гишүүд болон олон нийтэд танилцуулах, сурталчлах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг ханган ажиллаж байна.

2. НИТХ-ын төлөөлөгч (МАН, АН, ХҮН нам 3 бүлэгт), Нийслэлийн Ерөнхий архитектор, Нийслэлийн Засаг даргын орлогч нар 9 дүүргийн 7000 гаруй иргэдэд “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний талаар танилцуулсан.

3. Монголын Үндэсний олон нийтийн Радио телевизээр нээлттэй хэлэлцүүлгийг 9 удаа зохион байгуулсан. (2025.03.20-2025.05.01-ний өдрийг хүртэл)

4. Олон нийтийн нийгмийн сүлжээ буюу Фейсбүүк “Улаанбаатар 2040” цахим хуудсаар дамжуулан 7 рийл бичлэгийг сэдэвчлэн бэлтгэж, 70021 иргэнд хүргэв.

Зураг 7. “Улаанбаатар 2040” фейсбүүк хуудас.



5. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/540 дүгээр захирамжийн хүрээнд “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний төслийг Нийслэлийн 13 агентлагийн албан хаагчдад танилцуулсан.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах.

УИХ-ын тогтоолоор “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” батлагдсаны дараа Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, Засгийн газарт өргөн барихаар ажиллаж байна.

Улаанбаатар хотын Ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөөнд Захиалагчийн хяналт тавьж ажиллах.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1418 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны А/142 дугаартай “Нийслэл Улаанбаатар хотыг ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөө” боловсруулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2.3 дахь заалтыг үндэслэн НХААГ/20250103601 дугаартай Нийслэл Улаанбаатар хотыг ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөө боловсруулах үйлчилгээ үзүүлэгчийн сонгон шалгаруулалтаар “Нью Урбанизм” ХХК шалгарсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 03/1149 дугаартай албан бичгээр “Нью Урбанизм” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсний дагуу гэрээг байгуулан, захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах (14 хот)

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” хот байгуулалтын баримт бичгийн төслийн дагуу 14 хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврын төслийг боловсруулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний инженерийн шугам сүлжээний одоогийн байдалд үнэлгээ, хүртээмжийн судалгааг гаргаж, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т хүргүүлсэн.

Агросити дагуул хотын ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар “Агросити” дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг батлуулан НХААГ-т 2025 оны 01/217 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. НХААГ-ын даргын 2025 оны А/23 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдаж, нээлттэй тендерийг 2 удаа зарлаж, шаардлага хангаагүй тендерт тооцогдсон бөгөөд 3 дахь удаагийн тендерийг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зарласан. 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр тендер нээгдэх бөгөөд гүйцэтгэгч сонгон шалгарсны дараа захиалагчийн хяналт тавьж, үйл ажиллагааг төлөвлөгөөт хугацааны дагуу зохион байгуулахаар ажиллаж байна.

Зураг 8. Худалдан авах ажиллагааны үе шат. (Агросити)

АГРОСИТИ-3 УДАА НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСАН.



Шаргаморьт дагуул хотын ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах.

“Шаргаморьт” дагуул хотын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай хөрөнгө (1,065,800,000)-ийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2025 оны 24/50 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах” багц төсөл, арга хэмжээний багцаас санхүүжүүлэхээр тусгагдсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх захирамж гаргуулах тухай” албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/470 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

“Шаргаморьт” дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврын төслийг боловсруулан, байршлын схемийн хамт бэлтгэсэн. Захирамж батлагдаж гарсны дараа холбогдох ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.

Зураг 9. Шаардлагатай санхүүжилт болон захирамжийн явц. (Шаргаморьт)




Аргалант-Эмээлтийн суурьшлыг дагуул хот болгон хөгжүүлэх судалгааг хийх.


Аргалант-Эмээлтийн суурьшлыг дагуул хот болгон хөгжүүлэх судалгааг хийж, Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд Аргалант-Эмээлт хотыг дагуул хотын статустай байх тухай, дагуул хотын нэршлийг нэг томьёоллоор тусгах тухай саналыг “Хот төлөвлөлт судалгааны институт” ОНӨААТҮГ-т 2025 оны 01/245 дугаартай албан бичгээр хүргүүлэн тусгуулсан.

Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг дагуул хот, эдийн засгийн тусгай бүсэд нүүлгэн шилжүүлэх бодлого боловсруулж, саналыг дээд газарт хүргүүлэх.

Засгийн газрын шуурхай штабын 2025 оны 4 дүгээр хурлаар өгсөн үүрэг даалгаврын дагуу Хотын түгжрэл болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж буй зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, мега төслүүд, зам тээвэр, логистикийн сүлжээ, өнөөгийн байдлын суурь судалгаанд үндэслэн хот төлөвлөлтийн үндсэн 4 хүчин зүйлсийг харгалзан судалж, төвлөрөл, түгжрэл, агаар орчны бохирдолд хамгийн их нөлөөлж буй томоохон 9 зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх төсөл боловсруулсан.



Зураг 10. Зах, худалдааны төвийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт.



Дээрх зах худалдааны төвүүдийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэхэд шаардагдах төсөв, санхүүг тооцоолсон. Тус ажлыг үе шат дараатай нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай-д танилцуулсан.

Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж буй Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны суурьшлын бүсийн арьс шир, завод, ноосны анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг (28 нэгж үйлдвэр, 3 нэгж ноосны үйлдвэр болоод 10 дагалдах үйлдвэр) нүүлгэн шилжүүлэх хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Эмээлт эко аж үйлдвэрийн парк” ХК-д зохион байгуулсан.

Зураг 11. ХУД-ийн 20-р хорооны үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх уулзалт.



Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн салбар чиглэлээр төрөлжүүлж дагуул хотуудад нүүлгэн шилжүүлэх бодлого боловсруулж, саналыг дээд газарт хүргүүлэх.

Улаанбаатар хотын хамгийн их оюутан, суралцагчтай Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухаан Техникийн Их Сургууль, Хөдөө, Аж Ахуйн Их Сургууль, Улсын Багшийн Их Сургуулиудад сүүлийн 10 жилийн оюутны тоон мэдээлэл (шинээр элсэгч, төгсөгч, хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа) ирүүлэхийг 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 01/309,

01/306, 01/308, 01/307 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тус сургуулиуд албан бичгийн хариуг ирүүлсэн бөгөөд судалгаанд үндэслэн боловсруулалт хийж байна.

Сэлбэ дэд төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь “ББСМО” ХХК-тай “Сэлбэ дэд төв” орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн ТЭЗҮ, зураг төсөл, зөвлөх үйлчилгээ боловсруулах ажлын ЗҮ2025/01 дугаартай нэмэлт гэрээ байгуулан гүйцэтгэж байгаа бөгөөд гэрээний дагуу Барилгажилтын төсөл боловсруулах ажлын тайланг Нийслэлийн нутаг дэвсгэрт Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн Ерөнхий архитектор баталсан. “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК-д 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/538, 01/539 дугаартай албан бичгээр батлагдсан зураг төслийн ажлыг хүлээлгэн өгсөн.

Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын ажил эхлэх шав тавих ёслол 2025.05.29-ний өдөр болсон. “Сэлбэ хорин минутын хот корпорац” ХХК хариуцан гүйцэтгэж байна.

Зураг 12. Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын ажил эхлэх шав тавих ёслол.



Дарь-Эх, Монель, Тахилт олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийг батлуулах.

Шинээр байгуулах 3 олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын магадлалаар баталгаажсан эцсийн тайланг яаралтай ирүүлэхээр 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр “Зураг төсөл консалтинг ХХК”-д 01/274, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/595 дугаартай албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн. Мөн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/591 дугаартай албан бичгээр Барилгын хөгжлийн төвөөс тус ажлууд магадлалаар баталгаажсан эсэх дээр тодруулга авахаар хүргүүлсэн байна.

Зураг 13. Олон нийтийн төв.




Агросити, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албыг байгуулж, тусгай бүсийн үйл ажиллагааг эхлүүлэх.

Эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албыг байгуулах, Захирагч томилох, Бүтэц орон тооны хязгаар батлах тухай захирамжийн төслийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны ээлжит бус II дугаар хуралд танилцуулж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/117, Б/23, А/118, Б/24 дүгээр захирамжаар Агросити, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн захирагчийг томилж, бүтэц орон тоог баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/295 дугаар захирамжаар "Агросити" эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албаны дүрмийг батлуулсан.

Зураг 14. Эдийн засгийн тусгай бүс.



Тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжид татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах.

Тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгжид татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журмын төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр журмын төслийг батлах, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төсөл болон холбогдох төслийн хамт 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/613 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

"Хүннү" хотыг Нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд төрийн захиргаа, их дээд сургууль, тээвэр логистик, аялал жуулчлал, санхүүгийн төрөлжсөн дагуул хот болгон хөгжүүлнэ.

"Говь травэл" ХХК-аас 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 19/25 дугаартай албан бичгээр Хүннү хотын төв, засаг захиргааны бүсийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хот байгуулалтын баримт бичиг зөвшилцөх хүсэлт ирсний дагуу нийслэлийн Ерөнхий архитекторт танилцуулж, Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлтэй нийцүүлж дахин ирүүлэх талаар санал зөвлөмжийг өгсөн. Хүннү хотын ерөнхий төлөвлөгөөг нийслэлийн Ерөнхий архитектор баталсан.

Дамбадаржаа 63МВт-ын дулааны станцын ажлын зураг төсөл зөвшилцөж, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах.

Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Дамбадаржаа дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээ, 63МВт-ын дулааны станцын ажлын зураг төсөл зөвшилцсөн. Дулааны шугамын угсралтын ажил 100 хувьтай, дэд төвийн барилга угсралтын ажил 7 хувьтай хийгдэж байгаа бөгөөд зуухны сонголтын талаар хэлэлцэгдэж байна.

Зураг 15. Дамбадаржаа дулааны станцын төсөл.




Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутагт 3,8 га нэгж талбарт төлөвлөгдсөн Дэнжийн мянга дэд төвийн 80 Гкал/цаг-ийн хүчин чадалтай хийн түлшний дулааны эх дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2021 оны 5 дугаар хуралдааны тэмдэглэлээр дэмжигдсэн.

Яармаг хотын шинэ төвд 93МВт-ийн дэвшилтэт технологи бүхий дулааны эх үүсвэрийн газар олголтыг шийдвэрлүүлж, ТЭЗҮ, ажлын зураг төсөл зөвшилцөх.

Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/55, А/124 дугаартай тушаал, захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. 2025-2028 онд хэрэгжүүлэх орон сууцны төслүүдэд шаардлагатай 93МВт-ын Яармаг дулааны станц төлөвлөгдсөн. Тус эх үүсвэрийн байршил нь Улаанбаатар хотын 2040 хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан. Эх үүсвэрийн газар олголтын асуудлыг нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.

Зураг 16. Нисэх, Яармагийн ХЕТ-ний дулаан хангамжийн төлөвлөлт.



Яармаг хотын шинэ төвд 93МВт-ын дэвшилтэт технологи бүхий дулааны эх үүсвэр барьж ашиглалтад оруулснаар Нисэх, яармаг орчмын 15640 айл өрх төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдох боломж бүрдэнэ. Төр хувийн хэвшлээр санхүүжих нийт 79,350,00 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээс 2025 онд ТЭЗҮ, барилга угсралтын ажил хийгдэх 742.80 төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсөв, төсвийн тодотгол, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулахаар саналыг илгээсэн.

ИРГЭДИЙН АМЬДРАХ ОРЧНЫ ХҮРТЭЭМЖИЙГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ХОТЫН СТАНДАРТЫГ БАТЛАН МӨРДҮҮЛНЭ.

Хотын стандартыг батлуулах ажлын хүрээнд:

2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаар III ээлжийн 7 бүлгийн 16 хотын стандартыг батлуулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/555 дугаар албан бичгээр хотын стандартыг хэлэлцүүлэн батлуулах хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зөвлөлийн гишүүдээс санал авах хяналтын дагалдах хуудас авч хотын стандартын төслийг хянуулан баталгаажуулав.
- Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/7578 дугаар “Хотын стандартыг батлах тухай” болон “Хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” албан бичгээр 7 бүлгийн 16 хотын стандартыг хэлэлцэн батлуулахаар тогтоолын төслийг НИТХ-ын даргад хүргүүлэн ажиллав.
- НИТХ-ын 2022 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан UCS1603B:2022 “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага” хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах тухай НИТХ-ын 2025 оны ээлжит II хурлаар батлуулав.

Зураг 17. Хотын стандартад оруулсан нэмэлт өөрчлөлт

УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ ХК

2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 01/130 дугаартай албан бичгээр “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах санал ирүүлсэн.




UCS 1603B:2024
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ,
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийслэлийн Засаг даргын **2024** оны **1044** дүгээр захирамжаар байгуулагдсан хотын стандартыг батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийн II хуралдаанаар хэлэлцүүлж дараах өөрчлөлтийг оруулан НИТХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.

№	ОДОО БАЙГАА ЗААЛТ	НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ЗААЛТ
1	8.3. "Нийтийн тээврийн хэрэгслийн гадна талд реклам сурталчилгааны самбар байршуулахгүй байх"	8.3. Нийтийн тээврийн хэрэгслийн гадна талд сурталчилгааг байршуулахдаа нийт гадаргуугийн 60 хувиас хэтрэхгүй байх.
2	8.4. Нийтийн тээврийн хэрэгслийн гадна талд тухайн жилийн зорилтот жил болгон зарласан уриаг байрлуулж болно. Уриаг байрлуулахдаа дараах шаардлагыг хангасан байна.	8.4. Нийтийн тээврийн хэрэгслийн гадна талд сурталчилгаа байрлуулахдаа дараах шаардлагыг хангасан байна.
3	8.4.1. Тээврийн хэрэгслийн баруун талд зорчигчийн буух хаалганаас хойш, зурагт үзүүлсэн хэсэгт автобусны өндрийн 1/3-ээс хэтрэхгүй өндөртэй байрлуулах.	8.4.1. Тээврийн хэрэгслийн өндрийн 1/3-ээс хэтрэхгүй өндөртэй байрлуулах.
4	8.4.2. Нийтийн тээврийн хэрэгслийн гадаргууд уриа үг байрлуулахад дараах зүйлсийг хориглоно. Үүнд:	8.4.2. Нийтийн тээврийн хэрэгслийн гадаргууд сурталчилгаа байрлуулахад дараах зүйлсийг хориглоно. Үүнд:
5	8.4.2.1. Уриа үг байрлуулахдаа гэрэл буцаах нөлөөтэй хучилт, элементийг ашиглах, тээврийн хэрэгслийн үндсэн өнгийг алдагдуулах;	8.4.2.1. Сурталчилгаа байрлуулахдаа гэрэл буцаах нөлөөтэй хучилт, элементийг ашиглах;
6		+8.4.2.4. Автобусны урд, ард хэсэг болон цонх, хаалганы шилэн хэсэгт байрлуулах.

- НИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 25/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төслийн танилцуулга бэлтгэв.

Зураг 18. Журмын танилцуулга.



Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс ирүүлсэн 2025 оны 08-01/77 дугаар албан бичгийн дагуу Нийслэлийн хэмжээнд зам тээврийн ослоос үүдэлтэй замын түгжрэлийг бууруулах, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд ажлын даалгавар боловсруулан, саналыг нэгтгэн хүргүүлэв. Үүнд:

- Дрон нисгэх (зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг цаг алдалгүй тодорхойлон түргэн шуурхай ажиллах нөхцөлөөр хангах);
- Дундаж хурдны камер суурилуулах (хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн дундаж хурдыг хэмжих);
- Замын 1 дүгээр эгнээний зорчих хэсгийн нөхцөлийг стандартжуулах (1 дүгээр эгнээг олон улсын жишгээр будах, тусгай тоноглолоор тоноглох).

Батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх чиглэлээр:

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамжаар 2025 оныг “Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт “Хотын стандартын хэрэгжилтийг хангуулан хамтран ажиллах тухай” 2025 оны 01/301 дугаартай албан бичгийг хүргүүлэв. Мөн тус албан бичгээр батлагдсан 16 бүлгийн 68 хотын стандартын жагсаалт, 16 хотын стандартын зөвлөмжийн хуудсыг хүргүүлэв.

Зураг 19. Хотын стандартын зөвлөмж.

Байгууллагын <https://uds.ub.gov.mn/> веб сайтыг хөгжүүлэх зорилгоор нийслэлийн Хяналт шалгалтын газарт 2025 оны 01/9 дугаартай албан бичгээр хотын стандартын цахим хуудас боловсруулахад бичсэн эх кодыг шилжүүлэн авах тухай хүсэлтийг хүргүүлэв.

Хотын стандартыг хэвлэл, мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр сурталчлах, мэдээллээр хангах зорилтын хүрээнд:

Нийслэл Улаанбаатар хотод хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хотын стандартыг сурталчлан таниулах, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх хүрээнд дараах хэвлэл мэдээллээр хотын стандартын талаар ярилцлага өгч ажиллав. Үүнд:

1. “Нийслэлийн мэдээ” хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр 2025 оны 10 дугаар сарын 01-ээс эхлэн мөрдөгдөх 7 бүлэг 16 хотын стандартын талаар;
2. НИТХ-ын 2022 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан UCS 1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандартыг мөрдүүлэх зорилгоор телевиз, радиод нийт 3 удаагийн ярилцлага (Монголын радио, UBS телевиз, Монгол HD);
3. NTV телевизэд НИТХ-ын 2025 оны 25/09 дүгээр тогтоолоор батлагдсан UCS1501B:2025 “Орон сууцны барилгын дулаалга, гадна фасадад тавигдах шаардлага”, “UCS0301:2022 Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах техникийн ерөнхий шаардлага” хотын стандартын талаар;
4. Тэнгэр ТВ-д Худалдаа, үйлчилгээний гадна хаяг, стандартын талаар;
5. “Улаанбаатар мэдээ” цахим хуудсанд “UCS 0301B:2022 Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага” хотын стандартын талаар ярилцлага өгч ажиллав.

Зураг 20. Хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлага.



Хотын стандартын сургалт, арга зүйгээр хангах зорилтын хүрээнд:

Хотын стандартын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, сурталчлан таниулах хүрээнд “Хотын стандарт”-ын сэдэвчилсэн сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын 162 албан хаагч, 297 иргэн, хуулийн этгээдэд хотын стандартын сэдэвчилсэн сургалт орж, арга зүйгээр ханган ажиллав. Үүнд:

- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран гадна хаягийн байгууламжийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр;
- Баянгол дүүрэгт үйл ажиллагаа эрхлэн явуулдаг хоол үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч байгууллагуудад 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр;
- Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран аялал жуулчлал, амралт, зочид буудлын үйлчилгээ эрхлэгч нарт 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр;
- Оршуулгын үйлчилгээ эрхлэгч нарт 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр;
- Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 08/266 дугаартай албан бичгийн хүрээнд хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 32 албан хаагч хамрагдав.
- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэстэй хамтран хотын стандартын сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээд, аж ахуй нэгж байгууллагуудын 87 төлөөлөл хамрагдав.

- Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран гуравдугаар ээлжид батлагдсан UCS 1204В:2025 “Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартын сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллагуудын 25 төлөөлөл хамрагдав.
- Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт хотын стандарт, түүний хэрэгжилт, 3 дугаар ээлжийн хотын стандартын танилцуулга сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр тус тус зохион байгуулж, арга зүйгээр ханган ажиллав.

Зураг 21. Дүүргүүдэд зохион байгуулсан хотын стандартын сургалт.



2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/28 дугаар захирамжаар газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажилд 200,000,000 төгрөгийн эрх шилжиж ирсэн. Тус захирамжийн хүрээнд Инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, орон сууц болон олон нийтийн 23 барилгад газар хөдлөлтөд тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулахаар батлагдсан. Жагсаалтад:

- Ерөнхий боловсролын сургуулийн барилга - 3,
- Цэцэрлэгийн барилга - 1,
- Их, дээд сургуулийн барилга - 2 тусгагдсан.

Тус ажлын тендерийг худалдан авах ажиллагааны цахим системээр 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр олон нийтэд нээлттэй зарлаж, нээлтийг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хийж, ажил гүйцэтгэх гэрээг “Онч тэнхлэг” ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулан Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг хийх.

2024 оны НХААГ/20240103238 дугаартай гэрээний ерөнхий нөхцөлийн 4.5.2-т заасан үндэслэлээр НХААГ/20240103238-1 дугаартай сунгалтын гэрээг 2024 оны 11 дүгээр сарын 15-наас 2025 оны 08 дугаар сарын 15-ны дотор хийж гүйцэтгэхээр гэрээг шинэчлэн байгуулсан.

Захиалагчийн хяналтыг хийж буй ГЗБГЗЗЕГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 1/331 дугаартай албан бичгээр дундын тайланг хүлээн авсан дүгнэлтийг, “Геосан” ХХК, “Геокад” ХХК-ын түншлэлээс 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 02/27 дугаартай албан бичгээр тус тус ирүүлэхэд дундын тайланд ирүүлэх үндсэн 5 ажлаас 1 ажлын гүйцэтгэл буюу Өндрийн II ангийн сүлжээ байгуулах ажлын үр дүнг дутуу ирүүлсэн тул 2025 оны 02 дугаар сарын 25-ны 01/230 дугаартай албан бичгээр “Геосан” ХХК-д ажлыг гүйцээж ирүүлэх тухай 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/395 дугаартай албан бичгээр гэрээний ерөнхий нөхцөлийн 10.22-т заасны дагуу хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.05 хувиар алданги тооцох тухай мэдэгдэл тус тус хүргүүлсэн.

2025 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр засварласан ажлыг албан бичгээр ирүүлснийг хүлээн авч шалгахад эхний ээлжид хүлээлгэж өгөх 27 дугаар нэгж хорооллын зураглал дутуу, стандартын дагуу гүйцэтгээгүй байсан тул 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гүйцэтгэгч байгууллагатай уулзаж, дутуу зураглалыг шинэчлэн дахин ирүүлэхээр болсон. 2025 оны 06 дугаар сард багтаан хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.

Зураг 22. Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000 масштабтай байр зүйн зураг зохиох ажил.



ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ:

Дамбадаржаа дэд төв, Сэлбэ дэд төвийн цахилгаан хангамжийн ажлын хүрээнд 110/35/10кВ-ын Дамбадаржаа дэд станцын 17,900.0 сая төгрөгийг нийслэлийн төсөвт санал хүргүүлснээс 5,900.0 сая төгрөг батлагдсан бөгөөд дэд станцын газар олголтыг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн саналын дагуу өөрчлүүлэх хүсэлтийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд ЦДҮС ТӨХК болон ажлын зураг зохиогч Бодит чадал ХХК-ийн төлөөлөлтэй хамтран газар дээр ажиллаж судалгаа хийсэн. Их наран, Баянхошуу дэд станцын ажлын зураг төсөв батлагдсан, газар олголт шийдвэрлэгдсэн барилга угсралтын ажлын төсөв батлагдаагүй.

Их Наран орчимд баригда 2 хэлхээ 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*40кВА чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажилд нийт 27,809.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаагаас Нийслэлийн 2025 оны төсөв, төсвийн тодотголд 13,904.7 сая төгрөг тусгуулахаар саналаа албан бичгээр хүргүүлсэн.

Баянхошуу орчимд баригдах 2 хэлхээ 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*40кВА чадал бүхий дэд станцын барилга угсралтын ажилд нийт 15,708.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаагаас Нийслэлийн 2025 оны төсөв, төсвийн тодотголд 7,854.4 сая төгрөг тусгуулахаар саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан бичгээр хүргүүлсэн.

НИТХ-ын 2025 оны 25/48 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төвийн хэсгийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах зорилгоор СБД-ийн 1-р хорооны нутаг дэвсгэрт НЗДТГ-ын эзэмшлийн 10.2 га талбайд цахилгааны дэд станц

өргөтгөн барихтай холбогдуулан Эрчим хүчний яамны харьяа “Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн эзэмшиж буй 0.089 га газрын талбайн хэмжээг нэмэгдүүлж 0.12 га хэмжээтэйгээр төлөвлөсөн байршилд 110/10кВ-н Парк /Өргөө болж нэр солигдсон/ дэд станцын газрыг шийдвэрлүүлсэн. Дэд станцын 110кВ-ын кабель шугамын трассыг Бохир усны Туул коллекторын трасстай уялдуулж шийдэл гаргахаар “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК болон зураг төсөл зохиогч “Бодит чадал” ХХК судалгаа хийж байна.


Зураг 23. 110/10 кВ-ын Өргөө дэд станц, 110/35/10 кВ-ын Туул дэд станцын өргөтгөл.



Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны А/55, А/124 дугаартай тушаал захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хурлаар 13 дэд станцын газрын асуудлыг хэлэлцүүлсэн. Нийслэлийн 2025 оны төсвийн хөрөнгөөр хийгдэх 13 дэд станцын ажлын зургийн даалгаврыг батлуулан хангагч байгууллагад хүргүүлсэн. Дэд станцын ажлын төсөл хийгдэж байна. Төлөвлөж буй өргөтгөх шаардлагатай дэд станцын газар олголт, цахилгаан түгээх шугамын трассыг чөлөөлүүлэхээр “ЦДҮС” ТӨХК-тэй хамтарч судалсны дагуу Газар зохион байгуулалтын албанд газар олголтыг шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлсэн.

2025 онд нийслэлийн төсвийн 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хийгдэх 13 дэд станцын жагсаалтыг гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажилласан. Тус станцуудын газар олголтыг шийдвэрлүүлэх үүднээс “ЦДҮС” ТӨХК-тай хамтран Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд санал хүргүүлж ажиллалаа. ЭХЯ-наас техникийн нөхцөлүүд болон ажлын зургийн даалгавар боловсруулж НХОГ-т хүргүүлсэн.


Зураг 24. Цахилгаан хангамжийн төлөвлөлт.



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас Хан-Уул дүүргийн 18 дугар хорооны нутаг дэвсгэрт одоо барилгажаагүй байгаа хашаалсан газарт Хийн дулааны эх үүсвэрийг байршуулах боломжтой эсэх, газар олголт, Архитектур төлөвлөлтийн даалгавар тухайн байршилд батлагдсан эсэх талаар тодруулга авахаар хүсэлт ирүүлсний дагуу хариуг 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/233 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2025 оны А/24 дүгээр тушаалаар Экзим банкны санхүүжилтээр хийх Сэлбэ голын усан сан, үерийн хамгаалалтын барилга байгууламж, тохижилтын ажлын техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчин, нийгмийн стандартын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийн хуралд танилцуулж ТЭЗҮ-ний даалгавар боловсруулан батлуулан ажилласан.

Зураг 25. Төлөвлөлтийн концепц.



Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага хооронд байгуулсан Хамтран ажиллах тухай “НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027” батламжийн дагуу Хүн амын нутагшил суурьшлын хөтөлбөрийн Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийгдэх Сонгинохайрхан дүүргийн 26, 27, 4, 5 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 15, 16, 18, 20 дугаар хороодын нутаг дэвсгэр буюу Толгойт болон Бэлхийн голын байнгын халиа, тошин, үер усанд өртдөг хэсэгт голын эргийн хамгаалалт болон үерийн хамгаалалтын байгууламж барих, моджуулах, өвлийн цагт халиа үүсэхээс сэргийлэх үерийн хамгаалалтын суваг, хөрсний усны түвшин бууруулах шугам сүлжээ, хөв цөөрөм байгуулах ажлын хэрэгжилтийг хангах зураг төсөл, барилга угсралтад шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар тус газрын төлөөлөл ажиллаж, зөвлөх шалгаруулах үнэлгээний хороо, техникийн шийдэл зөвшилцөх 2 удаагийн хурал уулзалтад оролцож санал өгч ажилласан. Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг 2023 оны мэргэжлийн зөвлөлийн 43 дугаар хурлын шийдвэрээр боловсруулж батлуулан захиалагчид хүргүүлж ажилласан. 2 байршилд эхний эхлээд хийх ажлын зураг төсөл зөвшилцсөн бөгөөд Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Гүнжийн булаг орчмын хөв цөөрмийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Төрөлх Мөрөн” ХХК шалгаран барилга угсралтын ажил эхэлсэн. Толгойт голын ай сав дагуу 2600 метр үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг төслийг зөвшилцөж ажилласан. 2025 оны Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хурлаар хэлэлцүүлж тэмдэглэлийг холбогдох байгууллагууд руу хүргүүлж ажилласан.

Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/15 дугаартай тогтоол, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 09/221 дугаартай албан бичиг, Нийслэлийн нутаг дэвсгэрт Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн зөвлөлийн 07 дугаар хурлын шийдвэрээр:

- Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны хөрсний усны шүүрүүлийн байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар,
- Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар тус тус батлуулан захиалагчид хүргүүлж ажилласан.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх мэдээлэл харилцаа холбооны шугам сүлжээний 106 байршилд ажлын зураг зөвшилцөж, хот байгуулалтын мэдээллийн сан eBarilga системд баяжилт хийсэн. Тэг тэнхлэгийн акт олгох ажлын хүрээнд харилцаа холбооны шугамыг зөвшилцөн мэдээллийг eBarilga системд оруулсан.


АВТО ЗАМ:

“Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбож, Наадамчдын авто зам дээгүүр гүүрэн байгууламж барих” төслийг хэрэгжүүлнэ.

Туул авто замыг нүхтийн авто замын наадамчдын гудамжны авто зам дээгүүр барих 800м гүүрний тулгуур таарсан дулаан хангамж, ус хангамж ариутгах татуурга, гадна гэрэлтүүлэг, мэдээлэл харилцаа холбооны сувагчлал шилжүүлэх ажлын зураг төслийг зөвшилцөж Хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/949 дүгээр захирамжаар байгуулагдсан “ТУУЛЫН ХУРДНЫ ЗАМ” барих төслийн авто зам, замын байгууламжийн чиглэлээр нийслэлийн Замын хөгжлийн газраас ирүүлсэн “МСРС” ХХК-ийн боловсруулж буй Туулын хурдны замын төлөвлөлтийн трасст инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зөвшилцөж байна.

Зураг 26. Туулын хурдны замын төлөвлөлтийн трасс.



Яармаг шинэ төвийн гол гудамж зам, замын байгууламжийн төлөвлөлтийн зураг төслийг Нийслэлийн нутаг дэвсгэрт Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 29 дүгээр хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Холбогдох хэлтэс нэгжүүдээс санал авч зөвшилцөн, загвар зургийг батлуулахаар ажиллаж байна.

Зураг 27. Яармаг шинэ төвийн гол гудамж, замын байгууламж.



Наадамчдын авто замын дагуух хоёр талын туслах замын төлөвлөлтийн хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай төлөвлөлтийн трасст өртсөн газрыг чөлөөлөх боломжит байдлаар нийслэлийн 2025 оны төсвийн саналд тусгуулан ажиллах саналыг хэлэлцэж ажилласан.

Нийтийн тээврийн хүртээмж, төрлийг нэмэгдүүлэх ажлын хэсэгт санал хүргүүлэх, ажлын зураг төсөл зөвшилцөх, хотын мэдээллийн сан баяжуулж ажиллах хүрээнд:

Олон Улсын стандартыг бүрэн хангасан Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барьж байгуулах гүйцэтгэгч оролцогчийг сонгон шалгаруулах ажлын даалгавар боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, холбогдох саналыг даалгаварт тусгуулсан. “Метро”-ний нэгдүгээр чиглэл болох Улиастайн гүүрнээс, (Моносын уулзвар)-Сонсголонгийн зам хүртэлх шугамын зөвлөх үйлчилгээний ажилд холбогдох саналыг хүргүүлсэн. Метро барих төслийн зөвлөх үйлчилгээний ажлын орон зайн төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн хүрээнд санал зөвлөмж өгөх ажлын хэсэгт ажиллаж байна.

Нийтийн тээврийн хүртээмж, төрлийг нэмэгдүүлэх хүрээнд дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төслийг 3 байршилд зөвшилцөж ажиллаж байна. Үүнд:

- Төмөр замын 401км, ПК-4-14 3В-д байрлах авто машины нүхэн гарц /Хермис төвийн урд/,
- Төмөр замын 398км, ПК2-8 3В-д байрлах авто машины нүхэн гарц /Геологийн төв лабораторийн уулзвар/ шинээр барих төслийн дулааны шугамын өөрчлөлт, хүчитгэл,
- Эрчим хүчний гудамжны дахин төлөвлөлт, автозамын трасст өртсөн дулааны шугамуудыг хэсэгчилсэн өөрчлөлт, хүчитгэлийн ажлын зураг зөвшилцөж хот байгуулалтын мэдээллийн санд тусгасан.

Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд ажлын даалгаварт санал хүргүүлэх, мастер төлөвлөгөөг зөвшилцөх чиглэлээр:

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, нийтийн тээврийн чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төсөл хэрэгжүүлэх нэгжээс хэрэгжүүлж буй “Нийтийн тээврийн стратеги” төслийг танилцуулах хуралд оролцож санал, зөвлөмж өгч ажилласан.

Тусгай замын нийтийн тээврийг нэвтрүүлэх суурь судалгааны ажлын хэсэгт орж ажиллах хүрээнд:

Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, нийтийн тээврийн чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр Улаанбаатар хотын хөндлөн чиглэлд Нийслэлийн нийтийн тээвэрт тусгай замын автобус BRT төслийг гүйцэтгэж буй “Far east Mobility”-ийн ирүүлсэн тайлантай танилцаж 2024 оны 01/85 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид санал хүргүүлж ажилласан ба тухайн нэгжээс зохион байгуулсан хуралд оролцож, санал зөвлөмж өгч ажилласан. Тусгай замын тээвэр BRT Нисэх-Үндэсний цэцэрлэгт хүрээлэн хүртэлх хоёрдугаар чиглэлийн авто замтай хөндлөн огтлолцож байгаа болон авто зам дагуу таарч байгаа инженерийн шугам сүлжээний тодруулга бэлдэж танилцуулга хийсэн.

ЗОРИЛГО 3. ХУУЛИАР ХҮЛЭЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

Газарт нэвтрүүлсэн Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон Улсын стандартын сайжруулалтыг хийх.

ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартыг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Чанарын багийн 2024 оны ажлын гүйцэтгэлийн тайлан гаргасан.
- Чанарын багийн 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан Газрын даргаар батлуулав.
- Магадлах шатны аудитад бэлтгэн, сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан Газрын даргаар батлуулав.
- Газрын даргаар Удирдлагын дүн шинжилгээний журам, Үл тохирол болон залруулах арга хэмжээний журмыг Газрын даргаар батлуулав.
- Чанарын менежментийн тогтолцооны журам, Дотоод аудитын журмын төслийг боловсруулж байна.

MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын сургалтад албан хаагчдыг хамруулахаар сургалтын судалгаа хийж, сургалтад хамруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.


Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 захирамж “Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд тодорхой ажил санаачлан төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжүүлэх.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамж “Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд тус газраас хийж хэрэгжүүлэх ажлын саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт цахим хаягаар хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Бүтээн байгуулалтын жилийн 2025 оны төлөвлөгөө батлагдсан. Тус газрын чиг үүрэгт хамааралтай 7 заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хэрэгжилтийн тайлангийн төслийг нэгтгэж байна.

Бүтээн байгуулалтын жилийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хотын өнгөний шийдэлд нэгдсэн дүгнэлт хийж 47 нэгж хорооллын өнгөний кодыг тодорхойлж төлөвлөлтөд тусгуулсан.

Зураг 28. Улаанбаатар хотын өнгөний код.



- Хамбын овоо орчимд төлөвлөлтийн шийдэл суурь судалгааг хийж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2025 оны 03/2 дугаартай албан бичгийг хүргүүлж, Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрэм болон, явган зам, дугуйн зам алхахад таатай орчин бүрдүүлэх зорилгоор баримт бичигт Хот байгуулалтын суурь судалгаа санал өгсөн.

- ЦХХХЯ-ны Харилцаа холбоо, зохицуулах хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар Хаягжуулалтын өнөөгийн байдал, Хот байгуулалтын цахим систем /eBarilga/-ээр дамжуулан хаягийн мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл Нийслэлийн 9 дүүргийн төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын нийт 1191 албан хаагчдад сургалт зохион байгуулсан.
- Хан-Уул дүүргийн 08 дугаар хороо, Жаргалантын үерийн хамгаалалтын барилга угсралтын ажлын явц зогссон асуудлыг иргэн, аж ахуйн нэгжтэй зөвшилцөн ажлын явц үргэлжилж байна.
- Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/31 дүгээр “Хууль, тогтоомж, стандартын хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулах” тушаалын дагуу нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 591 зөрчлийг орон зайн мэдээллийн санд /Qfield/ бүртгэж, иргэдийг эрүүл, аюулгүй, орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хотын стандартыг мөрдлөг болгон ажиллах 110 зөвлөмжийг иргэн, хуулийн этгээдэд өгч ажиллав.
- Хотын стандартын хэрэгжилтийг хангуулах хүрээнд батлагдсан 16 бүлэг 68 хотын стандарт болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 16 хотын стандартын зөвлөмжийн хуудсыг Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01/301 дугаар албан бичгээр хүргүүлэв.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Мэргэжлийн зөвлөлийн хурал:

Нийслэлийн нутаг дэвсгэрт Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн хурлыг 29 удаа нээлттэй зохион байгуулж, 505 асуудал хэлэлцсэнээс 379 асуудал дэмжигдсэн. Хурлаас гарсан санал, тэмдэглэлийг баталгаажуулан www.uds.ub.gov.mn цахим хуудсанд байршуулав.

Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг:

2025 оны хагас жилийн байдлаар нийт 667 архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. Үүнд:

- Барилга, байгууламжийн төлөвлөлтийн даалгавар – 542
- Тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар – 44
- Авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар – 74
- Ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгавар – 7

2025 оны хагас жилийн байдлаар нийт 310 загвар зураг батлагдсан. Үүнд:

- Барилга, байгууламжийн загвар зураг – 276
- Тохижилтын ажлын загвар зураг – 24
- Авто зам замын байгууламжийн загвар зураг – 10

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн барилгажилтын төслийг хууль журам, норм ба дүрмийн дагуу батлах.

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд:

- Архитектур төлөвлөлтийн даалгавар 7,
- Загвар зураг 4,
- Барилгажилтын төсөл 2 тус тус баталсан.

ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫГ ЭРХЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/17 дугаартай тогтоолоор “Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Цэцэг төвийн уулзвараас Нийслэлийн Ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуулийн зүүн талын уулзвар хүртэлх 160 метр зам, гудамжийг Монгол Улсын анхны Ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат”-ын нэрээр нэршүүлэхээр батлагдсан.

Хот байгуулалтын мэдээллийн сангийн гудамж, зам талбайн мэдээллийн санг П.Очирбатын гудамжны мэдээллээр шинэчлэв.

Мөн байгууллагын www.uds.ub.gov.mn веб хуудсанд 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр гудамж талбайн ерөнхий мэдээлэл, шинээр нэршүүлсэн гудамжны талаар цаг үеийн мэдээ, мэдээллийг байршуулав.

Зураг 29. Шинээр нэршүүлсэн гудамж.



Барилга байгууламжийн хаяг дугаар:

Иргэн, хуулийн этгээдээс ирсэн 710 хүсэлтийг судлан, зөрчилгүй 848 барилгад шинээр, 124 барилгад дахин тодорхойлолт олгов. /нийт 23,366,400 төгрөг/
www.ebarilga.ub.gov.mn цахим системийн баригдсан барилга давхаргад шинээр 848 барилгад хаяг дугаар олгон, мэдээллийн санд бүртгэж, 124 барилгын мэдээллийг шинэчлэв.

Барилга байгууламжийн тэг тэнхлэгийн акт:

Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгөх 173 иргэн, хуулийн этгээдийн 342 блок барилга байгууламжийн актыг хүлээн авч, нийслэлийн Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэн, 173 акт үйлдэж өгөв.

Гүйцэтгэлийн байр зүйн зураг:

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний 892 байр зүйн зураг хүлээн авч хот байгуулалтын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг 44,7 га талбайгаар шинэчлэн баяжуулж, 749 акт үйлдсэн. Үүнээс байр зүйн зургийн стандартын дагуу хийгдээгүй, 88 зургийг буцаасан.

Хот байгуулалтын мэдээллийн сан дахь зурган болон тоон мэдээ, мэдээллээр үйлчлэх:

- Албаны нууцад хамаарах мэдээллийг хадгалах хамгаалах гэрээний дагуу 4 байгууллагад байр зүйн 154 планшет зураг,
- Газар зүйн мэдээлэл солилцох гэрээний дагуу 6 байгууллагад 35 төрлийн мэдээлэл,
- Албан бичгээр болон бусад хүсэлтээр 14 байгууллагад мэдээ, мэдээллийг хүргүүлсэн.
- Инженерийн шугам сүлжээний зурган мэдээлэл авах 111 хүсэлтийг хүлээн авч, тоон байдлаар /*dwg/ 55 га талбайн байр зүйн зураг, А3 хэвлэмэл байдлаар 16, А4 хэвлэмэл байдлаар 28 зурган мэдээллийг өгөв. /4,851,407 төгрөг/

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу газрын цахим хуудсандаа мэдээ мэдээллийг тогтмол оруулж, хуулийн хэрэгжилтийг хангах.


Байгууллагын www.uds.ub.gov.mn цахим хуудсыг MNS6285:2017 Төрийн байгууллагын вэбсайтад тавигдах шаардлага, стандартын дагуу тогтмол шинэчлэн ажиллаж байна. Үүнд:

- www.uds.ub.gov.mn цахим хуудсыг MNS6285:2017 Төрийн байгууллагын вэбсайтад тавигдах шаардлага, стандартын дагуу шинэчлэн хөтөлж, 16 төрлийн 207 мэдээ мэдээллийг байршуулав.
- Цахим хуудасны суурь өнгө, зургийг шинэчлэн байгууллагын лого, eBarilga хот байгуулалтын цахим системийн лого байршуулж линкийг холбосон.
- Үйлчилгээ цэс шинээр үүсгэж, 8 төрлийн 37 үйлчилгээг оруулж, Газрын даргын 2024 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан бүрдүүлэх материалын жагсаалт, өргөдлийн маягтыг байршуулав.
- Мэргэжлийн зөвлөлийн хурлын тов, жагсаалт, санал цэс нэмж хуучин цахим хуудсанд байршуулсан мэдээллийг нөхөн оруулж, шинэчлэн гарсан мэдээллийг тогтмол байршуулав.

Одон орон, геофизикийн хүрээлэнтэй газар хөдлөлтийн чиглэлээр хамтран ажиллана.

Одон орон, геофизикийн хүрээлэнгээс 2021 оны 170 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Хүчтэй газар хөдлөлтийн баллыг тодорхойлох багаж, төхөөрөмжийг Улаанбаатар хотын 4 бүсэд суурилуулан урт хугацаанд хамтран хэмжилт, судалгаа хийн ажиллаж байна. Багажийн хэвийн ажиллагаа, мэдээллийг grafana.iag.mn цахим хуудсаар хянан ажиллаж байна.

Зураг 30. Хүчтэй газар хөдлөлтийн балл.




Дэд төв, дагуул хот төлөвлөлтийн ажлын хүрээнд:

Хөгжлийн бүсүүдийг зөвлөн туслах чиглэлээр 5 чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Үүнд:

1. Агросити, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн дүрмийн төсөлд санал өгч үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна. Агросити тусгай бүсэд БНСУ-ын хөрөнгө оруулалтаар ухаалаг хүлэмж байгуулах тухай хамтарсан уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулж, зөвлөн чиглүүлж ажилласан.

2. Багахангай үйлдвэр технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан хөгжлийн чиг хандлагын төлөвлөлтийн судалгааг 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр гарган Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчид танилцуулсан.

Зураг 31. Багахангай үйлдвэрлэл технологийн парк.




3. Дагуул хотууд, эдийн засгийн тусгай бүсүүд болон үйлдвэрлэл, технологийн паркуудын удирдлага, төлөөлөл нартай хамтарсан уулзалтыг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Нийслэлийн Ерөнхий Архитектор, Хот байгуулалт, хотын стандартын газраас зохион байгуулж, хөгжлийн бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Зураг 32. Хамтарсан үүлзалт.




4. Паркийн нэгжээс паркийн удирдлагад төлөх хураамжийн хэмжээ, төлөх журмын төслийг боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, журмын төслийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

Зураг 33. Журмын хэрэлцүүлэг.



5. Үйлдвэрлэл технологийн паркуудын гүйцэтгэлд шинжилгээ хийж нийслэлийн Ерөнхий Архитекторт танилцуулсан.

Зураг 34. Үйлдвэр технологийн паркууд (Аналитик харьцуулалт)



Аж үйлдвэрийн паркуудын бүтээн байгуулалтыг дэмжиж “Аж үйлдвэрийн паркийн сэргэлт” хэлэлцүүлэг зохион байгуулах.

Эмээлт эко аж үйлдвэрийн паркт "Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд" сэдэвт хэлэлцүүлэг 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр паркуудад тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлсэн.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх инженерийн шугам сүлжээ, авто зам, замын байгууламжийн ажлын зураг төслийг хянах, зөвшилцөх, хэрэгжилтэд хяналт тавих.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх авто зам, инженерийн шугам сүлжээний шугам сүлжээний 812 байршилд ажлын зураг зөвшилцөх хүсэлт ирснээс 526 байршилд ажлын зураг зөвшилцөн мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн сан ebarilga цахимд системд оруулсан. Үүнд:

- Авто зам, замын байгууламж - 23
- Инженерийн бэлтгэл арга хэмжээ - 18
- Дулаан хангамж - 142
- Ус хангамж, ариутгах татуурга - 131
- Цахилгаан хангамж - 403
- Мэдээлэл, харилцаа холбоо - 95

Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох.

Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн хэрэгжилтийн хүрээнд Барилгын ажлын зөвшөөрөл авах 609 хүсэлтийг хүлээн авсан. Үүнээс:

- Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг олгосон - 380
- Судалж байгаа - 108
- Материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй - 121 хүсэлтийг буцаасан.

Барилгын ажлын 380 зөвшөөрлийн гэрчилгээ олгосноос Улс, Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалттай 69 барилга, байгууламжид зөвшөөрөл олгосон байна. Үүнд:

- Сургууль - 13
- Цэцэрлэг - 10
- Эмнэлэг - 7
- Олон нийтийн барилга - 39

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай 267 барилга, байгууламжид зөвшөөрөл олгосон байна. Үүнд:

- Барилга байгууламж - 158
- Цахилгаан хангамж - 94
- Барилга буулгах - 12
- Шугам сүлжээ - 3

Инженерийн дэд бүтцийн барилга угсралтын 44 ажилд зөвшөөрөл олгосон. Үүнд:

- Инженерийн шугам сүлжээ - 18
- Гудамж замын гэрэлтүүлэг - 1
- Цахилгаан хангамж - 25

Хот байгуулалтын талаар хууль, дүрэм, журам холбогдох баримт бичигт санал тусгах ажлын хүрээнд:

Газрын эрхлэн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үр нөлөөг нь сайжруулах зорилгоор судалгаа, шинжилгээ хийж, салбарын хууль, тогтоомжийг сайжруулах ажлын хүрээнд газрын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, бодит нөхцөл байдлыг үнэлэх, хууль, дүрэм, журамд шаардлагатай өөрчлөлтийг оруулах санал боловсруулж Нийт 12 хууль, дүрэм, журамд тусгуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан болно. Мөн Нийслэлийн Засаг даргын захирамжийн 6 төслийг хянаж, Газрын даргын А тушаалын 38 төсөл, Б 81 тушаалын төслийг тус тус хянаж ажиллав.

Зураг 35. Боловсруулсан, санал өгсөн эрх зүйн акт.



Иргэн, хуулийн этгээдийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг даргад холбогдох 24, Нийслэлийн Ерөнхий архитекторт холбогдох 7 газарт холбогдох 66 маргаанаас захиргааны 76, иргэний хэргийн 4 маргаанд холбогдох материалуудыг судалж тайлбар гаргах, нотлох

баримт хүргүүлэх, хэргийн материалтай танилцах, газрын үзлэг хэмжилтэд оролцох, гэрч асуухад байлцах зэрэг ажиллагаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 46 удаа оролцов. Анхан шатны шүүхийн 56, давж заалдах шатны шүүхийн 33 шүүх хуралдаанд тус тус оролцож, газрын үзлэгт 11 удаа очиж ажилласан байна. Нийт 80 хэрэг хянан шийдвэрлэх шатандаа байна. Он дамжсан 81, тайлант онд гардаг авсан 16 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаагаас тухай онд 16 хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэв.

Захиргааны сөрөг акт гарах тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу эрх ашиг нь хөндөгдөж буй давхардсан тоогоор 8 иргэн, хуулийн этгээдэд захиргааны сонсох ажиллагаа явуулсан.

НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 04 дүгээр хавсралтаар баталсан загвараар Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилго, 40 зорилтын хүрээнд 158 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн, тус газрын удирдлага Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/47 дугаартай хариуцлагын гэрээ байгуулан хэрэгжилтийн үр дүнд улирал бүр хяналт тавин ажиллаж байна.

Газрын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээний 2025 оны ажлын төлөвлөгөө гарган Газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр батлуулав. (Нийт 8 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.) Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт Бодлогын баримт бичгийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг албан бичгээр болон цахим системээр сар бүр тайлагнасан. Үүнд:

- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 2022-2025 оны байдлаар гарган ireeduiandar32@ulaanbaatar.mn цахим системээр,
- Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний саналыг hbth@gmail.com цахим хаягаар,
- Монгол Улсын төсвийн төсөлд тусгах саналыг www.pimis.publicinvestment.gov.mn цахим системээр,
- Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг sanal.hbth@gmail.com-ээр,
- Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хагас жилийн хэрэгжилтийг sanal.hbth@gmail.com-ээр.
- Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлт болон байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Үүнд:
- Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт tsogzoltserma@ulaanbaatar.mn цахим системээр (Засгийн газрын 4 тогтоолын 5 заалт -50%, Засгийн газрын хуралдааны 8 тэмдэглэл, 10 заалт - 66,2%, Засгийн газрын албан даалгавар -2 заалт- 60%),
- Нийслэлийн Засаг даргын Шуурхайн үүрэг даалгаврын нэгтгэлийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр mandakh@ulaanbaatar.mn цахим хаягаар,
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын 01, 02 албан даалгаврын хэрэгжилтийг oyunjargal.d@ulaanbaatar.mn, Orgiltsogtslokh.e@ulaanbaatar.mn цахим хаягаар,
- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилсан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг гарган Orgiltsogtslokh.e@ulaanbaatar.mn цахим хаягаар,

- Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлт (3 арга хэмжээ 86,6%)-ийг 2025 оны 02/62 дугаартай албан бичгээр,
- Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар ichinnorov611@gmail.com цахим хаягаар,
- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн 2025 оны хагас жилийн хэрэгжилтийг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар ichinnorov611@gmail.com цахим хаягаар,
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол (8 тогтоол)-ын хэрэгжилт (73,7%)-ийг гарган ichinnorov611@gmail.com цахим хаягаар,
- Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн хэрэгжилтийн явцын дэлгэрэнгүй танилцуулгыг 2025 оны 01 дүгээр сарын 15, 03 дугаар сарын 10, 04 дүгээр сарын 23, 05 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар нэгтгэн гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн Б.Аюушид дотоод удирдлагын ERP чатаар,
- Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Сахилга хариуцлага, төрийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/62 дугаар захирамжийн хэрэгжилтийг сар бүрийн 25-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт 2025 оны 01/311, 01/430 албан бичгээр хүргүүлэн ажиллав.

Хуулиар болон дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дахь хэсэгт заасны дагуу нээлттэй байлгах мэдээллийг www.shilen.gov.mn болон газрын www.uds.ub.gov.mn цахим хуудсанд байршуулан, мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Үүнд:

- 2025 оны 1, 2 дугаар улирлын байдлаар Шилэн мэдээллийн сан www.shilen.gov.mn цахим системд 5 бүлгийн 43 хуулийн заалтын дагуу холбогдох мэдээ, мэдээлэл,
- Шилэн данс www.shilendans.gov.mn цахим системд байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн биелэлт, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд нийт 55 мэдээллийг сар бүр байршуулсан.

Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг нийслэлд хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний төсөлд тусгуулах саналаа цахим системээр (choijooaltan@gmail.com, Orgiltsogtslohe@gmail.com, B.Enkhmandakh@gmail.com) болон албан бичгээр хүргүүлэв.

Газраас үзүүлж буй 9 төрлийн 37 нэр төрлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд <https://www.eBarilga.ub.gov.mn/>, <https://e-mongolia.mn/>, <https://www.e-business.mn> зэрэг цахим системээр үзүүлж, газрын <https://uds.ub.gov.mn/> цахим веб сайтад байршуулан мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна. Газрын www.uds.ub.gov.mn цахим хуудсыг MNS6285:2017 Төрийн байгууллагын вэбсайтад тавигдах шаардлага, стандартын дагуу хөтөлж, 10 төрлийн 140 мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулсан.

Газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүний нөөцийн ил тод байдлыг хангах.

Газрын төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний (стратегийн 9 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ) төслийг боловсруулсан.

Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн жинхэнэ албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн хүснэгтийн дагуу гарган ERP системээр дамжуулан Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэв. 26 албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн тогтоолгох санал хүргүүлсэн бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/578

дугаар захирамжаар батлагдаж шинээр тогтоосон зэрэг дэвийн нэмэгдлийг 05 дугаар сарын 01-ний өдрөөс олгов. (19 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах, шинээр 7 албан хаагчид)

Газрын үйл ажиллагаатай холбоотой нийт 110 тушаалыг боловсруулан баталгаажуулж, дотоод сүлжээнд цахимаар байршуулан тушаалын бүртгэл хөтлөн, хэрэгжилтийн мэдээг гарган ил тод байршуулж ажиллав. Үүнд:

- Газрын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 34,
- Хүний нөөцтэй холбоотой Б тушаал 76.

Нийт 108 захиргааны шийдвэрийн хяналтын дагалдах хуудас хөтлөн, хувийн хэргийг бүрдүүлж ажиллав. Ажлаас чөлөөлөгдсөн 21 албан хаагчийн, шилжин болон шинээр ажилд томилогдсон 20 албан хаагчийн мэдээллийг газрын цахим хуудсанд байршуулав.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалаар баталсан журмын дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 113 албан хаагч батлуулж, төрийн үйлчилгээний 43 албан хаагч Хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын дагуу 11 албан хаагчид албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж, албан үүргийг хавсран гүйцэтгэсний хөлсийг цалингийн 40 хувиар тооцож олгов.

СУРГАЛТ:

Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн хөгжлийн төв, нийслэлийн холбогдох бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 49 удаагийн 272 цагийн сургалтад (цахимаар 3, танхимын 46) давхардсан тоогоор 1037 албан хаагч (100 хувь) хамрагдав.

Хүснэгт 2. Алба, хэлтсүүдийн мэдээллийн цаг.

№	Сургалт зохион байгуулагч	Сургалтын нэр	Хамрагдсан өдөр
1	2	3	4
1	Ерөнхий архитекторын ажлын алба	“КАНООТ” танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн	2025.01.31
2	Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтэс	Кактус ажиллагаа	2025.02.05
3	Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс	Digital twin city, зарим хэрэгцээт программын мэдээлэл	2025.02.07
4	Хот байгуулалтын хяналтын хэлтэс	Байгууллагын соёл, хувь хүний хөгжил	2025.02.14
5	Хотын стандарт, хөгжлийн хэлтэс	Олон улсын эх хэлний өдөр	2025.02.21
6	Хуулийн хэлтэс	Эрүүл амьдралын хэвшил, хэв маяг - Цахим эмч Б.Баярбямба	2025.02.26
7	Хот төлөвлөлтийн хэлтэс	Жендерийн эрх тэгш байдал	2025.03.07
8	Барилга байгууламжийн чанар, стандартын хэлтэс	“Танин мэдэхгүй – Ёс зүй – Гоо зүй” философич С.Молор-эрдэнэ	2025.03.14
9	Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	- Сэтгэлзүйн сайн сайхан байдал ба сэтгэцийн эрүүл мэнд - Ментор Ж.Гантулга Сэтгэл засалч, донтох эмгэг судлаач, - МЕГА төслийн танилцуулга	2025.04.04
10	Барилга, хот байгуулалтын хэлтэс	Сөүл хотын ерөнхий төлөвлөгөө ба бүсчлэл, барилгын зөвшөөрөл хэрхэн олгогддог талаар Улаанбаатар дахь Сөүлийн	2025.04.11

1	2	3	4
		Үндэсний Их Сургуулийн Сквад төслийн удирдагч, Профессор И К Литэй хийсэн ярилцлага.	
11	Захиргаа, удирдлагын хэлтэс	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар	2025.05.02

Газрын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх.

Газрын даргаар Дотоод хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав. Төлөвлөгөөнд 15 ажил төлөвлөсөн. Үүнд:

Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар:

1. Архитектур төлөвлөлтийн даалгавар болон батлагдсан загвар зургийн дагуу үүссэн барилгын хувийн хэргийн бүрдэлд хийх хяналт, шалгалтын ажлыг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэв. Хяналт, шалгалтаар нийт 1815 хувийн хэргийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүрдүүлсэн эсэхийг шалгав. Үүнд:

- Хот төлөвлөлтийн хэлтэс 586,
- Барилга хот байгуулалтын хэлтэс 429.

Шалгалтыг:

- Газрын зөрчил,
- Төлөвлөлтийн зөрчил,
- Хүчингүй болсон эсвэл өөрчилсөн тохиолдолд кодификаци хийсэн эсэх,
- Техник алдаа гаргасан эсэх,
- UCS батлагдсан стандартыг мөрдсөн эсэх,
- Албан хаагчдын ажлын ачааллыг тодорхойлох
- Бусад чиглэлийн дагуу шалгаж тайлан гаргав.

2. Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цагийн бүртгэлийн www.timely.mn программ, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Ажлын цагийн тооцоо, илүү цагаар ажилласан тайлан, эмнэлгийн магадалгааг батлагдсан удирдамжийн дагуу шалган судалгаа, тайлан гаргав. Ажлын өдрийн 07:55 цагаас 17:00 цагийн хоорондох ажлын цаг ашиглалт, цагийн бүртгэл, Цаг бүртгэлийн Timely систем дээрх бүртгэл, өвчтэй, чөлөөтэй, тасалсан, нэмэлт үүрэг даалгаврын дагуу илүү цагаар ажилласан, цаг нөхөж бүртгүүлсэн зэрэг бүртгэл болон бусад чиглэлийн дагуу шалгаж дэлгэрэнгүй судалгаа, тайлан гаргав.

3. Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаартай тогтоолын хавсралт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг үндэслэн Барилга, байгууламжид хаяг дугаар олгох, мэдээллийн санд бүртгэх хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт шалгалт хийх удирдамжийн төслийг боловсруулан боловсруулан батлуулахаар бэлтгэн ажиллаж байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаар:

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн ажил үйлчилгээ, мэргэжил ур чадварын талаар гаргасан 17 өргөдөл, 28 албан бичгийг хууль, дүрэм, журам, барилгын норм дүрэм хангасан эсэх, шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж, албаны шалгалт хийж, хариу өгч шийдвэрлэсэн.

Төсөө, санхүү, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөн, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах.

Батлагдсан төсвийн хүрээнд зардал хэтрүүлэлгүй ажиллаж байна. Үүнд:

2024 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгө оруулалтын барьцаа дансны 11 ажлын 332.5 сая төгрөг, урьдчилж гарсан зардал дансны 1 ажлын 1,322.8 сая төгрөг, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа дансны 7 ажлын 9,150.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны 2 газрын 0.4 сая төгрөгийн авлагыг нэг бүрчлэн тулгаж тооцоо нийлсэн акт үйлдсэн.

Хөрөнгө оруулалтын барьцаа дансны мэдээг гаргаж дээд газарт хүргүүлсэн. Барьцаа дансанд 11 ажлын 332.5 сая төгрөг байснаас 3 ажлын 156.7 сая төгрөгийг олгосон.

2025 оны 05 сарын 31-ний өдрийн байдлаар төсвөөс 2,114.9 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны 30.0 сая төгрөгийн орлого олохоос 50.7 сая төгрөг олж, 2,197.5 сая төгрөг зарцуулахаас 1,615.7 сая төгрөгийг зарцуулсан.

Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст 16 албан хаагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны эмнэлгийн хуудасны 8,676,797 мянган төгрөгийн тооцоог хийж, хянуулж баталгаажуулав.

Газрын хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар:

- Үндсэн хөрөнгө -15,765,926,616.15 сая төгрөг
- Аж ахуйн материал - 28,327,599 сая төгрөг
- Бичиг хэргийн материал -6,263,665 сая төгрөг тооллогыг хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 12,892,765 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 15,945,599.80 сая төгрөгийн аж ахуйн материалыг холбогдох албан тушаалтнаар зөвшөөрөгдсөн шаардах хуудсаар материал тавьж, олгосон.

Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулах.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд:

- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1307 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч “Дэхан консалтент” ХХК-ийн эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эцсийн тайлангийн санхүүжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр олгосон.
- Нийслэлийн Зарсаг даргын 2024 оны А/1189 дүгээр захирамжийн хүрээнд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” хот байгуулалтын баримт бичиг боловсруулан ажлын гүйцэтгэгч “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ийн эцсийн тайланг хүлээн авч, 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, эцсийн санхүүжилтийг олгосон.
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/28 дугаар эрх шилжүүлэх тухай захирамжийн хүрээнд Газрын даргын А/22 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан “Онч тэнхлэг” ХХК-д гэрээ байгуулан, гэрээт гүйцэтгэлийн ажлаа хийж байна.
- Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын шатанд хэрэгжиж байна.
- Шаргаморьт дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх захирамж гаргуулах тухай” албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.
- Эрх шилжүүлэх тухай захирамж гарсны дараа ажлын даалгаврыг батлуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/28, А/68 дугаар захирамжийн хүрээнд Газрын даргын А/23 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулан Микросити ХХК-д гэрээ байгуулах эрх олгосон.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах.

Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын сургалт", "ХАСХОМ гаргах заавар", "Авлигын эсрэг хуульд заасны дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар баталсан "Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай" 5 дугаар тогтоолын танилцуулга" сэдэвт 2 удаагийн сургалтад цахимаар 61 албан хаагч хамрагдав.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг 2024 гаргасан 71, албан тушаалд томилогдсоноос хойш Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг 2024* мэдүүлсэн 5, их хэмжээний өөрчлөлт 2024+ мэдүүлсэн 4, нийт 80 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч, баталгаажуулав.

"ХАСХОМ 1", "ХАС хураангуй", "ХОМ хураангуй" тайлан мэдээ, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авсан (71 албан хаагч) тухай бүртгэлийн хамт цахимаар 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/237 дугаартай албан бичгээр, erdenemunkh.a@ulaanbaatar.mn цахим хаягаар холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичгийн шийдвэрлэлт:

2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1859 албан бичиг ирсэн. Үүнд:

- Хугацаанд нь шийдвэрлэсэн - 1823
- Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн - 0
- Шийдвэрлэх хугацаандаа судлагдаж байгаа - 36
- Шийдвэрлэлтийн хувь - 99.9%
- Шийдвэрлэлтийн дундаж 5 хоног байна.

Мөн хугацаанд нийт 1058 албан бичиг явсан, албан бичгийн шийдвэрлэлтийн явцад зөрчил гараагүй байна.

Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна" гэж заасны дагуу албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 03/935 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Боловсролын сайдын 2025 оны "Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах тухай зөвлөмж" болон Нийслэлийн Архивын газрын 2025 оны 01/65 дугаартай албан бичгээр ирсэн "Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай" зөвлөмжийн дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлтөд хос бичгийг нэвтрүүлэн, мөрдлөг болгон ажиллаж байна.

Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:

2025 оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс нийт 708 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс:

✓ Хугацаандаа шийдвэрлэсэн	666,
✓ Хугацаандаа судлагдаж байгаа	42,
✓ Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн	0
✓ Шийдвэрлэлтийн дундаж	94,0%
✓ Өргөдөл, гомдлын индекс	0.844 буюу "В" үнэлгээтэй,


- ✓ Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног, 9 цаг, 4 минут байна.

2024 оны мөн үетэй харьцуулбал:


- ✓ Өргөдөл, гомдлын хандалт 1031-с 323 буюу 31,3 хувиар буурсан,
 ✓ Шийдвэрлэлтийн дундаж 92%-с 2%-иар өссөн,
 ✓ Өргөдөл, гомдлын индекс 0.831-с 0.13 өссөн,
 ✓ Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9х-с 2 хоногоор буурсан үзүүлэлттэй байна.

Тус хугацаанд өргөдөл, гомдлын хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн зөрчил, дутагдал гаргаагүй байна.


Зураг 36. Өргөдөл, гомдлын хандалт эх үүсвэр:



Зураг 37. Өргөдөл, гомдлын төрөл:



Зураг 38. Шийдвэрлэсэн 209 өргөдөл, гомдолд хариу өгч, шийдвэрлэсэн хэлбэр:



Хүснэгт 3. Алба, хэлтсийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт.

Д/д	Алба, хэлтэс	Нийт	Шийдвэрлэсэн		Судлах шатанд	Зөрчил	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа
			Хугацаанд нь шийдвэрлэсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн			
1	2	3	4	5	6	7	8
0	Удирдлага	4	-	-	4	-	-
1	Хот төлөвлөлтийн хэлтэс	178	173	-	5	1	2 хоног, 12 цаг
2	Хот байгуулалтын хяналтын хэлтэс	175	159	-	16	-	11 хоног, 12 цаг
3	Барилга, хот байгуулалтын хэлтэс	163	154	-	9	-	6 хоног, 16 цаг

1	2	3	4	5	6	7	8
4	Ерөнхий архитекторын ажлын алба	43	40	-	3	2	11 хоног, 22 цаг
5	Захиргаа, удирдлагын хэлтэс	42	41	-	1	-	10 хоног, 2 цаг
6	Хуулийн хэлтэс	37	35	-	2	-	7 хоног, 13 цаг
7	Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	27	26	-	1	1	7 хоног, 23 цаг
8	Хотын стандарт, хөгжлийн хэлтэс	12	11	-	1	-	7 хоног, 2 цаг
9	Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс	11	11	-	-	-	4 хоног, 10 цаг
10	Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтэс	8	8	-	-	-	7 хоног, 7 цаг
11	Барилга байгууламжийн чанар, стандартын хэлтэс	8	8	-	-	-	8 хоног, 6 цаг
Хот байгуулалт, хотын стандартын газар		708	666	0	42	4	7 хоног, 9 цаг, 4 минут

Зөрчлийн үзүүлэлтийг 2024 оны мөн үетэй харьцуулбал 2024 онд 30 зөрчил бүртгэгдсэн бол 2025 онд 4 зөрчил бүртгэгдэж 86,7%-иар буурсан байна.

Зураг 39. Өргөдөл, гомдлын тэргүүлэх 5 хандалт.



2025 оны Эхний хагас жилийн байдлаар 623 иргэнээс нийт 708 өргөдөл, гомдол гаргаж, үүнээс 2-4 удаа давтамжтай хандсан 71 иргэн байна. Үүнд:

- 4 удаа хандсан 1 иргэн,
- 3 удаа хандсан 12 иргэн,
- 2 удаа хандсан 58 иргэн,
- 1 удаа хандсан 552 иргэн байна.


Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам” 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дах заалтын дагуу тус газрын чиг үүрэгт хамааралгүй асуудлаар ирүүлсэн нийт **200 гаран** өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу **буцаасан** байна.

Барилгын салбарын бүтээн байгуулалтын ажил эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас тухайн төлөвлөж буй газраа ямар зориулалтаар ашиглах боломжтой, мөн тухай орчмын хот байгуулалтын ерөнхий болон

хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний талаарх лавлагаа, мэдээлэл, тодорхойлолт хүссэн иргэдийн **хүсэлт** нийт өргөдлийн 17,0%-ийг эзэл байна.

Мөн хүн ам, барилгажилтын нягтрал ихсэж байгаатай холбоотой иргэдийн хараа хяналт нэмэгдэж, барилга, байгууламжийн ажил зөвшөөрөлтэй эсэхийг шалгуулах, барилгын ажил зогсоох, орчин тойрны аюулгүй байдалдаа санаа тавих, хот байгуулалт, төлөвлөлттэй холбоотой мэдээ, мэдээлэл авахаар хандсан иргэдийн **гомдол** нийт өргөдлийн 29,2%-ийг эзэлж байна.

Зураг 40. Өргөдөл, гомдлын хандалтыг өмнөх онуудын мөн үетэй харьцуулбал:



Өргөдөл, гомдлын хандалт сүүлийн 3 жилийн дунджаас 400 буюу 33,6%-иар буурсан үзүүлэлттэй байна. Жишээ нь: 2024 оны мөн үетэй харьцуулбал 323 буюу 31,3%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 онд үүссэн нийт 2150 архивын баримтыг хуваарийн дагуу 2025 оны 1 дүгээр улиралд бүрэн хүлээн авсан. Үүнээс:

- Байнга хадгалах хадгаламжийн нэгж - 1275
- Түр хадгалах хадгаламжийн нэгж - 122
- 70 жил хадгалах хадгаламжийн нэгж - 4
- Тусгай төрлийн хадгаламжийн нэгж -
- Зураг төсөл -

Газрын даргын 2025 оны өдрийн А/20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Архивын баримтын тооллогыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл тооллого хийж дуусгав. Тооллогын үр дүнд байгууллагын архивын санд 12,298 баримт, баримтын нийт хуудасны тоо 873,704 хуудас тоологдов.

ЗОРИЛГО 4. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Газраас үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах.

Газраас үзүүлж буй 9 төрлийн 37 нэр төрлийн үйлчилгээ авах хүсэлтийг үйлчилгээний ажилтан болон цахим хэлбэрээр 5060 иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан. Үүнд:

- Угтах үйлчилгээний цэгээр – 4142
- Цахим хэлбэрээр – 918

Газрын даргын 2024 оны А/32 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Газрын үйлчилгээний журам, хавсралт хяналтын хуудасны дагуу иргэн, хуулийн этгээдээс үйлчилгээний материалыг бүрдэл хангуулан авч, бүртгэсэн.

“Callpro” ХХК-тай хамтран иргэн, хуулийн этгээдэд газраас үзүүлж буй үйлчилгээ, албан бичиг, өргөдөл гомдлын талаарх мэдээ, мэдээллийг түргэн шуурхай дуудлага бүрийг алдахгүй утсаар хүргэх Операторын үйлчилгээ 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хүртэл нийт 19844 дуудлага хүлээн авч, холбогдох албан хаагч нартай холбож, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ой, “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг зохион байгуулах ажлын хүрээнд Газрын үйл ажиллагааг сурталчлах, газраас үзүүлж буй үйлчилгээний талаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгөх “Бид иргэдээ сонсож шийднэ” уулзалтын хуваарийг Захиргаа, удирдлагын хэлтсийн даргаар батлуулан, 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл 7 албан хаагч, үйлчилгээний ажилтантай хамтран зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Нийт 65 иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч, сэтгэл ханамжийн судалгаа авсан.

Байгууллагаас үзүүлдэг 9 төрлийн 37 үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн порталд (eMongolia) холбох.

eMongolia академи ТӨҮГ-ийн систем хөгжүүлэлтийн хэлтэс, eBarilga хот байгуулалтын цахим системийн хөгжүүлэгч Смарт дата ХХК-тай хамтран эхний 13 үйлчилгээг холболтын ажлын бүрэн дуусгахад цахим хурал зохион байгуулж, системийн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэн тестийн серверт туршилт хийж байна. Цахим системд хөрвүүлэн орсон өгөгдлүүдтэй холбоотой мэдээллүүдийг албан хаагчдын хүсэлтийн дагуу тухай бүр засварлан ажиллаж байна.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгын хүчитгэлийн зураг, норм дүрмийн шаардлага хангасан амины сууцны нэг маягийн загвар зургийг иргэдэд үнэ төлбөргүй ашиглуулах.

Амины сууцны нэг маягийн загвар зургийг нийт 6 иргэнд үнэ төлбөргүй ашиглуулсан байна. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны цахим хуудсанд Гамшигт тэсвэртэй, эрчим хүчний хэмнэлттэй Өрөгт бүтээц болон Төмөр бетон бүтээцтэй нэг маягийн амины орон сууцны ажлын зургийг байршуулан иргэд, олон нийтэд нээлттэй ашиглуулж байна.


БУСАД ТОМООХОН АЖЛЫН ХҮРЭЭНД:

1. Улаанбаатар хотод унадаг дугуй, цахилгаан скүтэрийн хөдөлгөөнийг сайжруулах зорилготой төлөвлөгдөж буй байршлыг иргэдийн оролцоотой хотыг хөгжүүлэхэд трасс схем зургуудыг бэлтгэж ажилласан.

Зураг 41. Дугуйн замын трасс.



2. Монголын Архитекторуудын эвлэлийн холбоо ТББ-д Хот төлөвлөлтийн тулгамдаж буй асуудлуудыг олон нийтийн дунд нээлттэй хэлэлцэх, санал солилцох зорилгоор хэлэлцүүлэг, уулзалт, уралдаан, үзэсгэлэн гаргах зэрэг арга хэмжээг хамтран зохион байгуулах талаар Нийслэлийн Ерөнхий архитекторын 2025 оны 04/2090 тоот албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу Нийслэлийн Ерөнхий архитекторын “Улаанбаатар хотын төвийн хэсгийн /Их тойруу/ ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга,



5. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/853 дугаар захирамжаар байгуулагдсан “Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах, зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “ЗОГСООЛ НЭГДСЭН ХӨТӨЛБӨР” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй. Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн Эрх зүйн бодлого зохицуулалтын хэлтсээс өгсөн зөвлөмжөөр Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ангилалд тусгагдаагүй тул “ХӨТӨЛБӨР” гэсэн нэршилтэй байх боломжгүй тул тус баримт бичгийг “АВТО ЗОГСООЛ НЭГДСЭН ТӨСӨЛ” нэртэйгээр боловсруулсан. Мөн ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн одоогийн нөхцөл байдалд нэн тэргүүнд шаардлагатай байгаа “Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто зогсоолын үйл ажиллагаа эрхлэх журам”-ыг дараах үндэслэлийн дагуу боловсруулсан.

Зураг 44. Зогсоол нэгдсэн төсөл боловсруулах үндэслэл.




6. Тээврийн хэрэгслийн зогсоолыг “Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн зогсоол ашигласны төлбөр авах үйл ажиллагааны журам”-д тусгагдсан ангиллын дагуу 6 төрлөөр тооцон, одоогийн газар ашиглалтын байдалтай уялдуулан, хэрэгцээнд тулгуурлан төлөвлөсөн.

Зураг 45. Тээврийн хэрэгслийн зогсоолын төрөл.



7. Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт Аялал жуулчлалын зориулалтаар олгосон газар олголт, Архитектур төлөвлөлтийн даалгаврын мэдээлэл бэлтгэв.


Зураг 46. Горхи-Тэрэлжийн төлөвлөлтийн даалгавар.



Монгол Улсын стандарт “Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага” MNS 6043:2019-ийн 4 дүгээр бүлгийн 4.2.8 (Амралтын газар, жуулчны бааз хоорондын зай 5 км-ээс доошгүй байна) дахь шаардлага болон Монгол Улсын стандарт “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6426:2013-ын 5 дугаар бүлгийн 5.2.1 (Эдэлбэр газар, бусад цогцолбор, амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын хоорондын харагдах зай 1 км-ээс багагүй байна) дэх шаардлагуудыг хэрэгжүүлэх санал боловсруулсан.

8. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлгүй хэсгүүдийг судалж, шийдэл боловсруулав.


Зураг 47. ХЕТ-нд тусгах шийдэл.



Нийслэлийн суурьшлын бүсийн хязгаарт багтаагүй, бүсчлэл тодорхойгүй газар олголт 21210 нэгж талбар байна. Эдгээр газар олголтуудыг Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулах талаар шийдэл боловсруулав.


9. Гэр хорооллын дахин төлөвлөлт болон ашиглалтын шаардлага хангахгүй төслийн зураглалын материалыг бэлтгэн боловсруулж ажиллав.

Зураг 48. Гэр хорооллын дахин төлөвлөлт болон АШХ төсөл.



10. 27 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний авто замын трассыг дахин зохион байгуулж, шинэчлэх санал боловсруулан зураглалын материал бэлтгэн ажиллав.

Зураг 49. 27 дугаар нэгж хорооллын авто замын трасс.



11. Нийслэлийн Засаг даргын 2024 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” А/1541 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/33 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр баталсан “Агаар бохирдуулагч суурин эх үүсвэр ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу “Гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын зуухны бүрэн бүтэн байдал, галлагааны аюулгүй байдал, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч хориглосон эд зүйлс шатааж буй эсэхэд хяналт шалгалт хийж, судалгаа гаргах, зөвлөмж зөвлөгөө хүргэх ажлыг холбогдох хууль дүрэм, журам, тогтоол, шийдвэр, стандартын хүрээнд хийж гүйцэтгэн илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, арилгуулах” ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 31 дүгээр хороог хамарсан хяналт шалгалтыг 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд зохион байгуулав.

Зураг 46. Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн хяналт шалгалт.

3-15кВт хүртэл хүчин чадалтай
айл, өрхийн халаалтын зуухны
судалгаа

When you submit this form, it will not automatically collect your details like name and email address unless you provide it yourself.

* Required

Судалгаа авсан байгууллагын мэдээлэл

Судалгаа авсан албан хаагчийн бөгөлх хэсэг

1. Судалгаа авсан байгууллага: *

Крилл үсгээр бичих

Enter your answer

2. Албан тушаал, овог нэр: *



Крилл үсгээр бичих





12. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/214 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Нийтийн байрны үйл ажиллагаа эрхлэгч болон оршин суугчдад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх аюулгүй байдлыг хангуулах” удирдамжийн дагуу НЭМГ, ЧД-ийн ЗДТГ-ын Цэргийн штаб, ЧД-ийн Цагдаагийн газар, ЧД-ийн Онцгой байдлын хэлтэс, ЧД-ийн хороодын Засаг даргын ажлын албатай хамтран хэлтсийн албан хаагчид 2025.02.20-2025.02.24-ний өдрийн хооронд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийтийн байрны үйлчилгээ эрхэлдэг иргэн, ААН-ийг урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамруулан ажилласан.

Зураг 45. Нийтийн байрны үзлэг шалгалт хийх, зөвлөн туслах.



13. Нийслэлийн Засаг даргын үүрэг даалгаврын дагуу "Нийслэлийн нутаг дэвсгэрт эзэнгүй нохой, муур барих, тоог бууруулах нэгдсэн арга хэмжээ"-д оролцож, 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Хан-Уул дүүргийн 12, 13, 14-р хорооны нутаг дэвсгэрт, 2025 оны 04 сарын 25-ны өдөр Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8, 23-р хорооны нутаг дэвсгэрт эзэнгүй

нохой, муур барих, тоог бууруулах нэгдсэн арга хэмжээнд нийт 36 албан хаагч оролцож, хорооны холбогдох албан тушаалтанд мэдээллийг өгч ажилласан. ажиллав.

Зураг 46. Эзэнгүй нохой, муур барих ажил.



14. Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд улс орон даяар зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургуулилтад 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагт тус газрын нийт 87 албан хаагч бүрэн хамрагдан ажиллав.

Зураг 47. Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургуулилт.



ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАЯРСАЙХАН

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ДАШЦЭЦЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:

ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Л.АДЪЯАСҮРЭН